



## ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА ИРГЭДЭД ЭЭЛТЭЙ БАЙНА УУ?

### МОНИТОРИНГИЙН ТУХАЙ

Хамтын хяналт сүлжээ (Эрхэм журам ТББ, Ёст хэм хөгжил ТББ, Олон нийтийн хөгжлийг дэмжих үндэсний төв ТББ) нь ННФ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр “Цагдаагийн байгууллагын үйлчилгээн дэх хүний эрхийн хэрэгжилт” мониторингийг 2013 оны 4-р улиралд хэрэгжүүлээ. Мониторингийг цагдаагийн байгууллагын үйлчилгээ, орчин нөхцөл нь иргэдийн эрх, эрх чөлөөг хүндэтгэж, хангасан, тэдний тав тухтай үйлчилгээ авах боломжийг бүрдүүлж чадаж буй эсэхийг тодруулах зорилгоор хийсэн бөгөөд стандартчилагдсан ажиглалт, асуулга, баримт бичгийн шинжилгээ, экспертийн, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийх арга зүйг ашиглалаа. Мониторинг хийх цагдаагийн нэгжийг сонгохдоо гэмт хэргийн гаралт, оршин суугаа хүн амын тоо, оршин суугчдын амьдралын хэв маяг, амьжиргааны түвшин, соёл урлаг, боловсролын байгууллагын төвлөрөл, хүн амын шилжилт хөдөлгөөн зэрэг хүчин зүйлийг харгалзан үзэж, Нийслэлийн цагдаагийн газар, СХД, СБД-ийн Цагдаагийн 1, 2-р хэлтэс, Төмөр замын цагдаагийн тасагт мониторинг хийлээ.

*Мониторингийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг “Хамтын хяналт” сүлжээний ТББ-уудаас авна уу.*

### МОНИТОРИНГИЙН ДҮНГЭЭС:

- Хүний нэр төр, эрхэм зэргийг үл хүндэтгэх, хувийн нууцыг задруулах зөрчил гарч байна.

*Хүчингийн гэмт хэргийн хохирогч 16 настай эмэгтэй О-гоос 4 байцаагч суудаг өрөөнд мэдүүлэг авсан бөгөөд энэ үеэр хулгайн гэмт хэрэгт сэжиглэгдсэн үеийн хөвгүүнээс мөн байцаалт авч байсан.*

*Хэрэг бүртгэгч нь хүлээлгийн орчинд зогсоод үйлчлүүлэгчдийн дэргэд хэрэгт холбогдогчийн эмээ рүү нь утсаар залган ярьж, дараа нь эмэгтэйд хандан “Чи ямар юмаа хийгээд айлын хүүхэд дагуулаад шоудаад байдаг юм бэ, эмээд чинь харин ч дэлгэрүүлж хэлсэнгүй” хэмээн сануулж байв.*

*Шинээр үйлчлүүлэхээр ирсэн хүмүүсийн хувийн мэдээллийг хүлээлгийн танхимд байгаа иргэдийн хажууд яриулах нь түгээмэл байна.*

*СБД-ийн цагдаагийн 2-р тасгийн хүлээлгийн танхимд сандлаас хүн гавласан байв. Энэ үед 34 үйлчлүүлэгч, хэрэг бүртгэлийн 3 ажилтан байсан.*

- Үйлчлүүлэгч олон цагаар, гадаа хүлээхэд хүрч байна.


*СХД-ийн цагдаагийн 2-р хэлтэс хүлээлгийн танхим багтаамжгүй, уулзалтын зохион байгуулалт муутайгаас жижүүрт уулзах хүнээ тэмдэглүүлээд, дуудах хүртэл нь гадаа хүлээдэг.*



- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Иргэд мэдээлэлгүйн улмаас нааш цааш олон дахин явах, хугацаа алдах, олон цагаар хүлээх нь түгээмэл байна.
- Мониторинг хийсэн байгууллагаас Төмөр замын цагдаагийн хэлтсийн мэдээллийн самбар хамгийн мэдээлэл сайтай нь байсан. Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм, үйл ажиллагааны стандарт, байгууллагын дотоод журам, үйлчлүүлэгчдэд хандсан дэлгэрэнгүй заавар, зөвлөгөөг байрлуулсан байв. Тухайлбал, тодорхой үйлчилгээг авах албан тушаалтны нэр, өрөөний дугаар, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, шийдвэрлэх шат дамжлагыг тусгажээ.
- Бусад байгууллагын тухайд үйлчлүүлж байгаа хүмүүст ач холбогдол багатай мэдээллүүд их байсан. Жишээ нь: анги, салбарын тэргүүний алба хаагчдын зураг, танилцуулга, байгууллагын дотоод журам, зар, эрэн сурвалжилж байгаа хүмүүсийн мэдээлэл, тодорхой арга хэмжээний үеэр авахуулсан зураг тавигджээ. Хууль тогтоомж, байгууллагын дотоод дүрэм, журмын талаарх мэдээлэл хэт албаны хэллэгтэй, жижиг үсгээр хэвлэгдсэн нь иргэдэд ойлгомж муутай байсан.
- Цахим хуудасны тухайд иргэдэд хэрэгцээтэй мэдээлэл бараг байсангүй. Харин Нийслэлийн цагдаагийн газрын цахим хуудсанд тухайн байгууллагын үйлчилгээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл байсан. Сонирхолтой нь СХД-ийн цагдаагийн 1-р хэлтсийн цахим хуудаст "Синус Дочи" ХХК-ийн мэндчилгээ, танилцуулга байлаа.
- Цагдаагийн байгууллага нь иргэдэд үйлчилгээ үзүүлж байгаа тул аюулгүй, хүртээмжтэй орчныг бүрдүүлэх шаардлагатай. Гэвч СБД-ийн цагдаагийн 2-р хэлтсээс бусад нь байр руу нэвтрэх налуу зам байхгүй байна. Аль ч цагдаагийн хэлтэст үйлчлүүлэгчдэд зориулсан ариун цэврийн өрөө байсангүй. Мөн мониторинг хийсэн бүх нэгжийн шал гялгар хавтангаар хийгдсэн тул цас, бороо орсон үед хүмүүс унаж гэмтэх өндөр магадлалтай байна.

#### МОНИТОРИНГИЙН ЯВЦАД ТУЛГАРСАН ХҮНДРЭЛИЙГ ДҮРЬДВАЛ:

- Цагдаагийн байгууллага дээр хийгдэж байсан өөр судалгааны ажилтай давхцсаны улмаас мониторингод оролцогчид судалгаанаас залхсан, дургүйцсэн хандлага ажиглагдлаа.
- Үйлчлүүлэгчид айж болгоомжлох хандлага их байснаас мониторингод оролцохоос татгалзах, эсхүл цагдаагийн алба хаагчдад мэдээлэх зэрэг тохиолдол гарсан.
- Цагдаагийн байгууллагын талаарх иргэдийн ойлголт хандлага хэт туйлширсан байгаагийн улмаас нэг талыг барьсан, цагдааг буруутгасан, худал ташаа мэдээлэл өгөх нь түгээмэл байсан.
- Цагдаагийн байгууллагын хүлээлгийн танхим хэт жижиг, жижүүрийн цагдаагийн харцанд захирагдаж байснаас ажиглалт хийх, баримтжуулахад хүндрэл гарч байсан. Мөн зарим тохиолдолд тодорхой зорилгогүй бол гар гэж хөөгдөж байлаа.
- Хүлээлгийн танхимд байсан судлаачдыг дагах, илт сүрдүүлэх, заналхийлэх цөөн тохиолдол гарсан.



Дүүргийн цагдаагийн хүлээлгийн танхимд сандлаас хүнийг гавлаж буй нь



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

Шинээр эхлэн гаргаж буй энэхүү цувралаар Төрийн Бус Байгууллага (ТББ)-уудын төрийн үйлчилгээнд хийж байгаа Мониторингийн гол дүнг хүргэх юм. Нээлттэй Нийгэм Форумын санхүүжилт, арга зүйн дэмжлэгтэйгээр хийгддэг ТББ-уудын мониторингоор төрийн үйлчилгээний ил тод, хариуцлагатай байдал амьдралд хэр бодитой хэрэгжиж байгааг баримтаар баталгаажуулж дүгнэлт, зөвлөмж гаргадаг билээ. Мониторингийн үр дүнг олон нийтэд хүргэхийн сацуу төрийн үйлчилгээг цаашид боловсронгуй болгох чиглэлээр мониторинг хийсэн зарим ТББ-ууд нөлөөллийн үйл ажиллагаагаа явуулдаг юм.

Жамъян гүний гудамж -5/1,  
Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар - 48,

Утас: (976-11) 313207  
Факс: (976-11) 324857